

**ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН ОНӨТҮГ-Т ХҮРГҮҮЛСЭН
АЛБАН БИЧИГ, АЛБАН ШААРДЛАГА**

№	Огноо	Дугаар	Хаана	Утга
1	2017.05.29	02-02/1622	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Шорлогын цэгүүдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажиллах тухай албан бичиг
2	2017.05.29	02-01/1613	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Стандарын шаардлагад нийцсэн техник хэрэгслээр олон нийтэд үйлчилэх, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах тухай албан бичиг
3	2018.04.20	02-02/1356	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Хуулийн хэрэгжилт хангуулах тухай албан бичиг
4	2018.07.25	02-01/2780	НМХГ-аас Нийслэлийн өмчийн харилцааны газарт	Түрээсийн гэрээг цуцлуулах тухай албан бичиг
5	2018.08.17	02-02-224/671	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Зөрчил арилгуулах тухай 16 заалт бүхий албан шаардлага
6	2018.09.05	140	НИТХ-ийн тэргүүлэгчдийн тогтоол	Хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ авах тухай
7	2019.03.15	02-02/945	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Хариу хүргүүлэх тухай албан бичиг
8	2018.09.14	02-02/3511	НМХГ-аас Нийслэлийн өмчийн харилцааны газарт	Түргэн үйлчилгээний цэгүүдийн гэрээг цуцлуулах тухай дүн мэдээ ирүүлэх албан бичиг
9	2018.08.22	4/1280	НӨХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Түрээсийн гэрээ цуцлах тухай албан бичиг
10	2018.07.27	47	Нийслэлийн прокурорын газар	Прокурорын тогтоол Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай
11	2018.07.30	02-03/2850	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Прокурорын тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай албан бичиг
12	2018.07.27	43	Нийслэлийн прокурорын газар	Прокурорын тогтоол Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай
13	2018.07.27	44	Нийслэлийн прокурорын газар	Прокурорын тогтоол Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай
14.	2019.05.21	02-14/173	БЗД дэх МХХ-ээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-д худалдаа үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад	Хүүхдийн тоглоомын аюулгүй байдлыг хангах тухай
15	-	-	-	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т хийсэн хяналт шалгалтын танилцуулга

Хэрэгжүүлэгч
РЭГ ДЭХ
НЫ ОРГОН ЧӨЛ
ТАР ХОТ. 1337

Тай нэ
хүн а
н Зас
г хан
й ба
а зох

аа

ы

и

**ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН ОНӨТҮГ-Т ХҮРГҮҮЛСЭН
АЛБАН БИЧИГ, АЛБАН ШААРДЛАГА**

№	Огноо	Дугаар	Хаана	Утга
1	2017.05.29	02-02/1622	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Шорлогын цэгүүдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажиллах тухай албан бичиг
2	2017.05.29	02-01/1613	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Стандарын шаардлагад нийцсэн техник хэрэгслээр олон нийтэд үйлчилэх, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах тухай албан бичиг
3	2018.04.20	02-02/1356	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Хуулийн хэрэгжилт хангуулах тухай албан бичиг
4	2018.07.25	02-01/2780	НМХГ-аас Нийслэлийн өмчийн харилцааны газарт	Түрээсийн гэрээг цуцлуулах тухай албан бичиг
5	2018.08.17	02-02-224/671	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Зөрчил арилгуулах тухай 16 заалт бүхий албан шаардлага
6	2018.09.05	140	НИТХ-ийн тэргүүлэгчдийн тогтоол	Хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ авах тухай
7	2019.03.15	02-02/945	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Хариу хүргүүлэх тухай албан бичиг
8	2018.09.14	02-02/3511	НМХГ-аас Нийслэлийн өмчийн харилцааны газарт	Түргэн үйлчилгээний цэгүүдийн гэрээг цуцлуулах тухай дүн мэдээ ирүүлэх албан бичиг
9	2018.08.22	4/1280	НӨХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Түрээсийн гэрээ цуцлах тухай албан бичиг
10	2018.07.27	47	Нийслэлийн прокурорын газар	Прокурорын тогтоол Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай
11	2018.07.30	02-03/2850	НМХГ-аас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т	Прокурорын тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай албан бичиг
12	2018.07.27	43	Нийслэлийн прокурорын газар	Прокурорын тогтоол Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай
13	2018.07.27	44	Нийслэлийн прокурорын газар	Прокурорын тогтоол Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай
14.	2019.05.21	02-14/173	БЗД дэх МХХ-ээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-д худалдаа үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад	Хүүхдийн тоглоомын аюулгүй байдлыг хангах тухай
15	-	-	-	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т хийсэн хяналт шалгалтын танилцуулга



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо Ж Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас 7011-1284, Факс (976-11) 31-15-09
<http://www.ub-inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.05.29 № 02-01/1613

Танай _____ -ны № _____ -г

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
ОНТҮГ-ЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУУЛ ТАНАА

Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дотор талбайд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэд нь Монгол улсын хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцээгүй тоглоом бусад техник хэрэгслээр үйлчилж байгаа нь иргэдийн амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулж болзошгүй байна.

Иймд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийг стандарт шаардлагад нийцсэн тоглоом, техник хэрэгслээр олон нийтэд үйлчилж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй байна.

Хувийг Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Худалдаа үйлдвэр үйлчилгээний хэлтэст

ДАРГА



С.ЭРДЭНЭЧУЛУУН

A5 тоот



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
 Нийслэлийн засаг захиргааны III байр
 Утас: 7777-5000, Факс: 7777-5120
<http://www.ub.inspection.gov.mn>
 E-mail: ub_info@inspection.gov.mn

"ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН"
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУУЛ
 ТАНАА

2018.04.20 № 02-02/1356
 танай _____ -ны № _____ -т

Г Хуулийн хэрэгжилт хангуулах тухай Г

Танай Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүйгээр ил задгай худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэд нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь "Үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх", Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь "Стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх", НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журмын 6.3 дахь "Зөвшөөрөгдсөн цэгээс бусад нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ил задгай хүнсний болон барааны худалдаа /жимс, ногоо, шорлог, төрөл бүрийн машинт болон чингэлэгийн худалдаа, бусад/ эрхлэхийг хориглоно", 6.10 дахь "Үйлчилгээний стандартгүй ажил, үйлчилгээ эрхлэхийг хориглоно" гэж тус тус заасныг зөрчиж байна.

Иймд танай байгууллага Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоод хяналт шалгалтын журам тогтоож ажиллана" гэж заасны дагуу дотоодын хяналт шалгалтыг явуулж зөвшөөрөлгүйгээр ил задгай худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллана уу.

Хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцохыг мэдэгдье.

ДЭД ДАРГА



Б.БАТШАГАЙ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284. Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.05.29. № 02-02/1622
танай _____-ны № _____-г

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
ОНӨТҮГ-Т

Танай байгууллагын эзэмшлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй шорлогны цэгүүд нь Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг зөрчихөөс гадна хүрээлэн буй орчинд утаа ихээр ялгаруулж, амрагчдын ая тухтай байдлыг алдагдуулж байгаа тул уг үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч ажиллана уу.

ДЭД ДАРГА



Б.БАТШАГАЙ

3.6, 5.1.1, 5.4.7, 5.5.2, 5.7.1, түрээсийн гэрээний 4.1 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

Иймд Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, түрээсийн гэрээний холбогдох заалтуудыг зөрчсөн хавсралт хүснэгтэд дурьдсан түргэн үйлчилгээний цэгүүдийн түрээсийн гэрээг цуцалж 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэрсийг албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудас.

Хувийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга С.Амарсайханд.

ДАРГА



Л.ЭРДЭНЭЧУЛУУН

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 07 өдрийн №-01629801 тоот албан бичгийн хавсралт

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2018 оны 02-02/373 дугаартай "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжтай хяналт шалгалтаар гэрээг цуцлах түргэн үйлчилгээний цэгийн жагсаалт

№	Хүн, хуулийн этгээдийн нэрс	Үйл ажиллагааны чиглэл	Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал	Утас	Гэрээний огноо	Гэрээний дугаар	ТУЦ-ийн дугаар	Хавсралт 1
1	ОАСИСМОН ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Т.Долгион, Менежер	88553320	2015.07.01	119539		1
2	Байгалиа дээдлэе ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Н.Наранхүү	99102101	2015.05.01	119529		3
3	Монгол говь халзан морьт ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Б.Баярмаа захирал, Б.Шижиртуяа хариуцагч	99196787 99857584	2014.08.01	119503		4
4	Жандаг хордон ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Л.Баярсайхан захирал, Т.Энхбаяр хариуцагч	99198696 99620725	2015.07.01	119546		5
5	З.Ганбат	Худалдаа, хоол үйлдвэрлэл	З.Ганбат Ц.Болор-Эрдэнэ хариуцагч	99101886 99094657	2015.05.01	119521		6
6	Замбага Эрдэм ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Б.Янжинлхам	99338668	2014.05.01	119508		7
7	Энх мөнхийн зам ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	З.Энхбаатар	88703355	2014.05.01	119506		8
8	Онон шовгор ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	П.Лүндээхандан	99120354	2015.10.10			9
9	Хосболор ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Н.Нямсүрэн	99103066	2015.07.01	119545		10



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ч.ОДНАСАН ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2018.07.25 № 02-01/2780
танай _____-ны № _____-т

┌ Түрээсийн гэрээг цуцлуулах тухай ┐

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдөр баталсан 02-02/373 дугаартай "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ болон түүнд түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 28 түргэн үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 07 дугаар сарын 23-ны өдрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ.

Нийслэлийн өмчийн харилцааны газар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ, түргэн үйлчилгээний цэгийг түрээслэгч талуудын хооронд байгуулсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-нд зөвхөн худалдаа, үйлчилгээний зориулалтаар түрээслүүлэхээр заасан байна.

Хяналт шалгалтаар дээрх 29 түргэн үйлчилгээний цэгүүдийн 20 нь харьяалах нутаг дэвсгэр дэх мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлээгүй, эрүүл ахуй, стандартын шаардлага хангахгүй нөхцөлд хоол үйлдвэрлэл /хуушуур, бургер, шаржигнуур тахиа, салат гэх мэт/-ийн үйл ажиллагаа явуулсан, батлагдсан жор технологийн зааваргүй, ажилтнаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулаагүй, хувийн ариун цэвэр сахидаггүй, мэргэжлийн тогоочгүй, цэвэр, бохир усны төвлөрсөн эсхүл хэсгийн системд холбогдоогүй, түүхий эд, бүтээгдэхүүн нь баталгаажилтгүй байгаа нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.5, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 10.1.7, Худалдааны үйлчилгээ. Худалдааны газрын ангилал, нэр томъёо MNS 6506:2015 стандартын 4.5.7, Хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005 стандартын

1150504005



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

Г ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН Г
ОНӨТҮГ-ЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУУЛ
ТАНАА

2018.08.17 № 02-02-224/641
таныг _____-ны № _____-т

Зөрчлийг арилгуулах тухай

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 02-02/373 дугаартай "Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийх тухай" удирдамжийн дагуу Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Эрүүл ахуйн тухай, Тамхины хяналтын тухай, Хог хаягдлын тухай, Эрчим хүчний тухай, Барилгын тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Газрын тухай, Байгаль орчны багц хуулиуд, Худалдааны газар, түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 5021:2007, Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005 стандартууд, Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм, Хийн аж ахуйн техник ашиглалтын дүрмийн хэрэгжилтэнд Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаанд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын дарга С.Эрдэнэтуул болон холбогдох ажилтан, албан хаагчдыг байлцуулан 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 07 дугаар сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар дараах хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг зөрчсөн зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэд нь харъяа дүүрэг дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлээгүй нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь 1-ийн ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх, урьдчилсан хяналт шалгалтад хамрагдах/ заалтыг;

2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй түргэн үйлчилгээний цэгүүдийн ажлын байр стандарт, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, төвлөрсөн болон хэсгийн цэвэр, бохир

115050008707

усан хангамжийн системд холбогдоогүй нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь /стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх/, Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх /үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан зураг төслийн дагуу баригдсан, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна/ заалтыг;

3. Хүнсний түүхий эд, бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажилтын бичиг баримтыг бүрдүүлж хэвшээгүй, эрүүл ахуйн шаардлагын дагуу хадгалаагүй нь Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх /хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна/, Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь /бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг эрүүл ахуйн шаардлагын дагуу хадгалж, зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэнэ/ заалтуудыг;

4. Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй түргэн үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаа эрхлэгч нар шаазан тавгыг гялгар уутаар бүрж түүнд дээр халуун хоолыг таваглан олгож хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх /хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах/ заалтыг;

5. Худалдаа үйлчилгээний газруудад ажиллаж буй ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд бүрэн хамрагдаагүй нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь /хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах/ заалтыг;

6. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд үйл ажиллагаандаа эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлээгүй, бүртгэл хөтлөлтгүй нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх /үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх/ заалтыг;

7. Үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хангалтгүй тавьдаг, дотоод хяналтын нэгж ажилтангүй нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний едрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн өөрийн компанийн "Дотоод хяналтын журам"-ыг боловсруулан баталж, мэргэжлийн боловсон хүчин бүхий дотоод хяналтын нэгжийг байгууллагын даргын шууд удирдлага дор зохион байгуулж ажиллана заалтыг;

8. Гудамж, зам, талбайн зарим эрвээхэй гэрэлтүүлэгүүдийн тэжээлийн блокууд шатсан, шон доторх холболтын утаснууд өгөршиж муудан ашиглалтын шаардлага

нөлөөллийн ерөнхий үнэлгээ/, 7.1.2 дахь /байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ/, 7.2 дахь /байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ/, 8 дугаар зүйлийн 8.1 дэх /энэ хуулийн 7.4.3-т заасны дагуу гарсан дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, хугацааг тодорхой заана/, 8.2 дахь /байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ/ заалтуудыг;

11. Хөрс, ус, орчны агаарын шинжилгээг тогтмол хийлгэдэггүй нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дэх /орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана/ заалтыг;

12. Хог хаягдлын гэрээ байгуулах, хяналт тавих, гадаад дотоод орчны цэвэрлэгээ хариуцсан нэгж ажилтангүй байгаа нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.17 дахь /үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх/ заалтыг;

13. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгээгүй нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.4 дэх /газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/, 58 дугаар зүйлийн 58.2 дахь /тариалангийн газраас бусад ангиллын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг дараахь үзүүлэлтээр гаргана/, 58.5 дахь /газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана/ заалтуудыг;

14. Газрыг гэрээнд заасан зориулалтаас /Цэцэрлэгт хүрээлэн/ бусад зориулалтаар ашиглаж байгаа нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх /гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах/ заалтыг;

15. Эзэмшил газрынхаа зүүн ба зүүн хойд хэсэг, мөн урд хэсгийн хил заагийн эргэлтийн цэгийг газар дээр тэмдэгжүүлээгүй нь Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.12 дахь /ерөнхий болон оноосон хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийн байрлалыг байгалийн байнгын биет, хүний бүтээсэн байгууламж, тэмдэглээс, геодезийн байнгын цэг, тэмдэгтүүдийг ашиглан газар дээр нь тэмдэглэж газрын кадастрын зурагт буулгана/ заалтыг,

16. Ус ашиглах дүгнэлт, эрхийн бичиггүй, ус авах цэгт тоолуур байрлуулж баталгаажуулаагүй нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх /иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ энэ хуулийн 28.4-т заасан этгээдэд гаргана/, 28.4 дэх /хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана/, 28.11 дэх /энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ/, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх /ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах/ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дах заалтын дагуу дээрх зөрчил, дутагдлуудыг арилгах, шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг **ШААРДАХ** нь:

1. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийг харьяа дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст бүртгэлжүүлж хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ажлыг зохион байгуулах;

2. Зориулалтын бус байранд хоол үйлдвэрлэл болон ил задгай талбайд шорлог шарах үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж таслан зогсоож, цаашид зөрчлийг гаргахгүй байх тал дээр байнгын хяналт тавьж ажиллах;

3. Гарал үүсэл нь тодорхой, чанар, аюулгүй байдлын баталгаажилттай, хүнсний бүтээгдэхүүнээр худалдаа, үйлчилгээ явуулах;

4. Хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахдаа зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй, баталгаа шинжилгээтэй нэг удаагийн болон хуванцар сав баглаа боодол хэрэглэх;

5. Худалдаа үйлчилгээний газруудад ажиллаж буй ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд бүрэн хамруулах;

6. Худалдаа үйлчилгээ эрхлэгч нарын үйл ажиллагаанд эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх;

10	Заламт гол ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Ц.Ууганбаяр	96687844	2015.07.01	119542	11
11	Анчин фүүдс ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Ч.Чулууннагд	88078588 99088947	2015.07.01	119556	12
12	Иргэн И.Болор- Эрдэнэ	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	И.Болор-Эрдэнэ	88115026	2015.05.01	119523	13
13	Эрхэт төмөр ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Б.Баярхүү	99191573	2015.07.01	119551	14
14	ҮЦХ-д бизнес эрхлэгчдийн холбоо ГҮТББ	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	З.Ганбат	99101886	2015.05.01	119521	15
15	Соёл жилүүр ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	И.Алтангэрэл	99900993	2014.05.01	119507	18
16	Байгалиа дээдлье ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Н.Наранхүү	99184810	2015.05.01	119529	22
17	Наху баян ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Б.Эрдэнэбаатар	99996032	2015.05.01	119528	23
18	Нью эффект ХХК	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Ч.Уламбаяр	9669037	2017.05.01	119516	25
19	Иргэн Н.Мэнджаргал	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Н.Мэнджаргал	89019181	2015.10.01	119558	27
20	Иргэн Г.Нина	Худалдаа, хоол Үйлдвэрлэл	Г.Нина	95176629	2014.05.01	119512	28

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ



Х.НАРАНБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ
ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



А.ДАВААЖАВ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ГЭРЭЛТУЯА

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

С.ЭРДЭНЭТУУЛ



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот


Хяналт шалгалтын мөрөөр
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨҮГ-т хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын мөрөөр илэрсэн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын шаардлага хангаагүй зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргуулахгүй байх, хоол хүнсний болон бусад үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч, үр дүнгийн талаархи мэдээллийг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д үүрэг болгосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН



1110100514



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

“ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУУЛ
ТАНАА

2019.03.15 № 02-02/945
танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханд ирүүлсэн 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 80 тоот албан бичиг тус байгууллагад шилжин ирсэнтэй танилцлаа.

Тус газраас 2018 онд “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-т Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 02-02/373 тоот удирдамжийн хүрээнд хяналтын 5 чиглэлээр хяналт шалгалт хийж, улсын /ахлах/ байцаагчийн 3 албан шаардлага хүргүүлж, 3 акт үйлдэж, нийт 20 зөрчлийн хэрэг нээж 2900000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Шалгалтын танилцуулгыг 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад илэрсэн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын шаардлага хангаагүй зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргуулахгүй байх, хоол хүнсний болон бусад үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч, үр дүнгийн талаарх мэдээллийг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид үүрэг болгосон 140 тоот тогтоол гарсан.


Дурдагдсан зөрчил дутагдлууд нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журмын 3.6 дахь /дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ/, 3.7.3 дахь /илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах/, 3.7.6 дахь /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Хүнсний тухай хуулийн 10.1.1 дэх /хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж,


1150501975

үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах/, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5.1.2 дахь /хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг өөрөө хариуцах/, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13.1 дэх /Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт шалгалтын журам тогтоож ажиллана/ заалтуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой болно.

Танай байгууллага Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй бөгөөд түрээсийн гэрээгээр ажиллаж байгаа иргэд, аж ахуй нэгжүүд, байгууллагын гадна талбайд зөвшөөрөлгүйгээр худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллах бүрэн боломжтой.

Иймд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалтын явуулын цэгийг байршуулж ажиллуулах боломжгүй, шаардлагагүйг үүгээр мэдэгдье.

ДЭД ДАРГА  Б.БАТШАГАЙ



110273981 9120799

7. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн өөрийн компанийн "Дотоод хяналтын журам"-ыг шинэчлэн боловсруулан баталж, мэргэжлийн боловсон хүчин бүхий дотоод хяналтын нэгжийг байгууллагын даргын шууд удирдлага дор зохион байгуулж хяналт тавьж ажиллах;

8. Гудамж, зам, талбайн эрвээхэй гэрэлтүүлэгүүдэд үзлэг хийж эвдрэл, гэмтэл үүссэн хэсгүүдэд шаардлагатай засвар тордолтын ажлыг гүйцэтгэх;

9. Цахилгааны хуваарилах самбаруудад нь анхааруулах санамж, зурагт хуудас байршуулах;

10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэн, батлуулах;

11. Хөрс, ус, орчны агаарын шинжилгээ хийх цэгийг тогтоон, итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх;

12. Хог хаягдлын гэрээ байгуулах, хяналт тавих, гадаад дотоод орчны цэвэрлэгээ хариуцсан нэгж ажилтанг томилон ажиллуулах;

13. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хийлгэх;

14. Эзэмшил газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах;

15. Эзэмшил газрынхаа зүүн ба зүүн хойд хэсэг, мөн урд хэсгийн хил заагийн эргэлтийн цэгийг газар дээр тэмдэгжүүлэх;

16. Гүний худагт тоолуур байршуулж баталгаажуулан, ус ашиглах дүгнэлт, эрхийн бичиг, зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авч, ус ашигласны төлбөр төлж хэвших;

Дээрх ажлуудыг 2018 оны 09 дүгээр сарын 03-ны дотор гүйцэтгэж хариуг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт албан бичгээр ирүүлэх.

Албан шаардлагыг биелүүлээгүй, хариуг албан ёсоор хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын дагуу хариуцлага тооцохыг мэдэгдье.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ХҮНСНИЙ ЧАНАР, СТАНДАРТЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.ХОНГОР

ХҮНСНИЙ ЧАНАР, СТАНДАРТЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Х.ЧИМГЭЭ

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.ИДЭРБАТ

үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах/, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5.1.2 дахь /хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг өөрөө хариуцах/, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13.1 дэх /Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт шалгалтын журам тогтоож ажиллана/ заалтуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой болно.

Танай байгууллага Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй бөгөөд түрээсийн гэрээгээр ажиллаж байгаа иргэд, аж ахуй нэгжүүд, байгууллагын гадна талбайд зөвшөөрөлгүйгээр худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллах бүрэн боломжтой.

Иймд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалтын явуулын цэгийг байршуулж ажиллуулах боломжгүй, шаардлагагүйг үүгээр мэдэгдье.

ДЭД ДАРГА



Б.БАТШАГАЙ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2018.09.14 № 02-02/3511

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ч.ОДНАСАН ТАНАА

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т зөрчилтэй үйл ажиллагаа явуулж буй 20 түргэн үйлчилгээний цэгүүдийн гэрээг цуцлуулах тухай албан бичгийг танай байгууллагад хүргүүлсэн.

Иймд дээрхи газруудад авч хэрэгжүүлсэн ажлын дүн мэдээг 2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

ДЭД ДАРГА



Б.БАТШАГАЙ

1150510064



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу-1, Хөвсгөл лэйк сити товер-8/1, 3-р давхар
Утас/Факс: (976-11) 32-02-48
<http://www.umch.ub.gov.mn>

“ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН”
ОНӨҮГ-Т


2018.08.22 № 4/280
танай _____-ны № _____-т

Түрээсийн гэрээ цуцлах тухай

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталсан 02-02/373 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд танай хүрээлэнгийн талбай дээр үйл ажиллагаа явуулдаг 29 ширхэг “Түргэн үйлчилгээний цэг”-ийн үйл ажиллагаанд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрүүдэд хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, түрээсийн гэрээний холбогдох заалтуудыг зөрчсөн “Түргэн үйлчилгээний цэг”-ийн түрээсийн гэрээг цуцлах тухай албан бичиг ирүүлсэн тул хавсралтад дурдагдсан 20 ширхэг “Түргэн үйлчилгээний цэг”-үүдийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцалж, хамтран ажиллахыг мэдэгдье.

Хувийг: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт.

ОРЛОГЧ ДАРГА



Д.АРИУНБААТАР

115050000885

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2018 оны 02-02/33 дугаартай "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжтай хяналт шалгалтаар гэрээг цуцлах түргэн үйлчилгээний цэгийн жагсаалт

Хавсралт 1

№	Хүн, хуулийн этгээдийн нэрс	Үйл ажиллагааны чиглэл	Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал	Утас	Гэрээний огноо	Гэрээний дугаар	ТҮЦ ийн дугаар
1	ОАСИСМОН ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Т.Долгион, менежер	88453320	2015.07.01	119539	1
2	Байгалиа дээдлэе ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Н.Наранхүү	99102101	2015.05.01	119529	3
3	Монгол говь халзан морьт ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Б.Баярмаа захирал, Б.Шижиртуяа хариуцагч	99196787 99657584	2014.08.01	119503	4
4	Жандаг хордон ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Л.Баярсайхан захирал, Т.Энхбаяр хариуцагч	99198696 99620725	2015.07.01	119546	5
5	З.Ганбат	Худалдаа, хоол үйлдвэрлэл	З.Ганбат Ц.Болор-Эрдэнэ хариуцагч	99101886 99094657	2015.05.01	119521	6
6	Замбага Эрдэм ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Б.Янжинлхам	99338668	2014.05.01	119508	7
7	Энх мөнхийн зам ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	З.Энхбаатар	88703355	2014.05.01	119506	8
8	Онон шовгор ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	П.Лүндээжанцан	99120354	2015.10.10		9
9	Хосболор ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Н.Нямсүрэн	99103066	2015.07.01	119545	10



“ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУУЛ
ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2019. 03. 15 № 02-02/945
танай _____ -ны № _____ -т

Г Хариу хүргүүлэх тухай Г

Танай байгууллагаас Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханд ирүүлсэн 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 80 тоот албан бичиг тус байгууллагад шилжин ирсэнтэй танилцлаа.

Тус газраас 2018 онд “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-т Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 02-02/373 тоот удирдамжийн хүрээнд хяналтын 5 чиглэлээр хяналт шалгалт хийж, улсын /ахлах/ байцаагчийн 3 албан шаардлага хүргүүлж, 3 акт үйлдэж, нийт 20 зөрчлийн хэрэг нээж 2900000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Шалгалтын танилцуулгыг 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад илэрсэн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын шаардлага хангаагүй зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргуулахгүй байх, хоол хүнсний болон бусад үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч, үр дүнгийн талаарх мэдээллийг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид үүрэг болгосон 140 тоот тогтоол гарсан.

Дурдагдсан зөрчил дутагдлууд нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журмын 3.6 дахь /дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ/, 3.7.3 дахь /илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах/, 3.7.6 дахь /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Хүнсний тухай хуулийн 10.1.1 дэх /хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж,

1150501974



НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
ПРОКУРОРЫН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Үйл ажиллагаа, ашиглалтыг түр
зогсоох тухай

Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Б.Гипэлмаа би Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбатаас 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн ОАСИСМОН ХХК-нд холбогдох зөрчлийн хэрэгт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа явуулж байгаа 1 дүгээр цэг нь хүнсний стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоох тухай санал, холбогдох зөрчлийн 1802000295 дугаартай хэргийг 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч хянаад ОЛСОН нь:

ОАСИСМОН ХХК нь Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэг ажиллуулахдаа хүнсний стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх журам зөрчиж, хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/-ийн үйл ажиллагаа явуулсан нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэг, Худалдааны газрын ангилал, нэр томъёо MNS 6506:2015 стандартын 4.5.7, Хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005 стандартын 3.6, 5.1.1, 5.5.2, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хийсэн түрээсийн гэрээний 4.1 дэх заалтуудыг зөрчсөн, хүний эрүүл мэндэд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн байх тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Зөрчлийн 1802000295 дугаартай хэрэгт ОАСИСМОН ХХК-ний Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоосугай.

2.Зөрчлийн хэргийн холбогдогч ОАСИСМОН ХХК-ний захиралд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг тайлбарлан өгсүгэй.

3.Прокурорын тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг даруй хэрэгжүүлэхийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол,

0610496

соёлын хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбатад даалгасугай.

ХЯНАЛТЫН ПРОКУРОР, ХУУЛЬ
ЦААЗЫН АХЛАХ ЗӨВЛӨХ



Б.ГИПЭЛМАА

ТАНИЛЦСАН:
ХОЛБОГДОГЧ

Б.Түмэндалар.



НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
ПРОКУРОРЫН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Үйл ажиллагаа, ашиглалтыг түр
зогсоох тухай

Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Б.Гипэлмаа би Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн хүнсний чанар, стандартын улсын ахлах байцаагч Б.Хонгор 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн иргэн Н.Мэнджаргалд холбогдох зөрчлийн хэрэгт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа явуулж байгаа 27 дугаар түргэн үйлчилгээний цэг нь хүнсний стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоох тухай санал, холбогдох зөрчлийн 1802000299 дугаартай хэргийг 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдөр хүлээн авч хянаад ОЛСОН нь:

Иргэн Н.Мэнджаргал нь Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэг ажиллуулахдаа хүнсний стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх журам зөрчиж, хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/-ийн үйл ажиллагаа явуулсан нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэг, Худалдааны газрын ангилал, нэр томъёо MNS 6506:2015 стандартын 4.5.7, Хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005 стандартын 3.6, 5.1.1, 5.5.2, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хийсэн түрээсийн гэрээний 4.1 дэх заалтуудыг зөрчсөн, хүний эрүүл мэндэд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн байх тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Зөрчлийн 1802000299 дугаартай хэрэгт иргэн Н.Мэнджаргалын Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоосугай.

2.Зөрчлийн хэргийн холбогдогч Н.Мэнджаргалд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг тайлбарлан өгсүгэй.

3.Прокурорын тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг даруй хэрэгжүүлэхийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнсний аюулгүй

0610507



ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ
ХҮРЭЭЛЭН ОНӨТҮГ-ЫН ЗАХИРАЛ
С.ЭРДЭНЭТУУЛ ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2018.17.30 № 02-03/2850
танай _____-ны № _____-т

Г Прокурорын тогтоолын хэрэгжилтийг Г
хангуулах тухай

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-т 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 23-ны өдрүүдэд хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтаар хуульд заасан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх журам зөрчиж хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/-ийн үйл ажиллагаа явуулсан ОАСИСМОН ХХК-ийн 1 дүгээр түргэн үйлчилгээний цэг, иргэн Д.Жавхлангийн 3 дугаар түргэн үйлчилгээний цэг, Монгол говь халзан морьт ХХК-ийн 4 дүгээр түргэн үйлчилгээний цэг, Жандагхордон ХХК-ийн 5 дугаар түргэн үйлчилгээний цэг, иргэн З.Ганбатын 6 дугаар түргэн үйлчилгээний цэг, иргэн Н.Мэнджаргалын 27 дугаар түргэн үйлчилгээний цэг, иргэн Г.Нинагийн 28 дугаар түргэн үйлчилгээний цэгүүдэд Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээр зөрчлийн хэрэг нээж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх 7 түргэн үйлчилгээний цэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурорын 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 43, 44, 45, 46, 47, 48, 49 дугаар тогтоолууд гарсан тул дараах арга хэмжээг авч хариуг ирүүлнэ үү. Үүнд:

1. Прокурорын тогтоолыг холбогдогчид танилцуулж гарын үсэг зуруулан ирүүлэх;
2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээг авч, дотоодын хяналт тавьж ажиллах;

Холбогдох эрх бүхий албан тушаалтан: Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбат-88066130, хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч Б.Хонгор-99106816.

Хавсралт 12 хуудас.

ДЭД ДАРГА



С.ДАВААСҮРЭН

115050410

10	Заламт гол ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Ц Ууганбаяр	96687844	2015.07.01	119542	11
11	Анчин фүүдс ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Ч. Чулуунзагд	88078588 99088947	2015.07.01	119556	12
12	Иргэн И.Болор- Эрдэнэ	Худалдаа, хоол үйлдвэрлэл	И.Болор-Эрдэнэ	88115026	2015.05.01	119523	13
13	Эрхэт төмөр ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Б.Баярхүү	99191573	2015.07.01	119551	14
14	ҮЦХ-д бизнес эрхлэгчдийн холбоо ГҮТББ	Худалдаа, хоол үйлдвэрлэл	З.Ганбат	99101886	2015.05.01	119521	15
15	Соёл жигүүр ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	И.Алтангэрэл	99900993	2014.05.01	119507	18
16	Байгалиа дээдлье ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Н.Наранхүү	99184810	2015.05.01	119529	22
17	Наху баян ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Б.Эрдэнэбаатар	99996032	2015.05.01	119528	23
18	Нью эффект ХХК	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Ч.Уламбаяр	9669037	2017.05.01	119516	25
19	Иргэн Н.Мэнджаргал	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Н.Мэнджаргал	89019181	2015.10.01	119558	27
20	Иргэн Г.Нина	Худалдаа, хоол үйлдвэрлэл	Г.Нина	95176629	2014.05.01	119512	28



НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
ПРОКУРОРЫН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Үйл ажиллагаа, ашиглалтыг түр
зогсоох тухай

Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Б.Гипэлмаа би Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбатаас 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн "Жандаг хордон" ХХК-нд холбогдох зөрчлийн хэрэгт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа явуулж байгаа 5 дугаар цэг нь хүнсний стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоох тухай санал, холбогдох зөрчлийн 1802000292 дугаартай хэргийг 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч хянаад ОЛСОН нь:

"Жандаг хордон" ХХК нь Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэг ажиллуулахдаа хүнсний стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх журам зөрчиж, хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/-ийн үйл ажиллагаа явуулсан нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэг, Худалдааны газрын ангилал, нэр томъёо MNS 6506:2015 стандартын 4.5.7, Хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005 стандартын 3.6, 5.1.1, 5.5.2, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хийсэн түрээсийн гэрээний 4.1 дэх заалтуудыг зөрчсөн, хүний эрүүл мэндэд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн байх тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Зөрчлийн 1802000292 дугаартай хэрэгт "Жандаг хордон" ХХК-ний Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоосугай.

2.Зөрчлийн хэргийн холбогдогч "Жандаг хордон" ХХК-ний захиралд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг тайлбарлан өгсүгэй.

3.Прокурорын тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг даруй хэрэгжүүлэхийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол,

0610502



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС**

Эх Утгагчид Судамд 1-р Саягчид Дүрэм
Улаанбаатар улс 11004
Телефон: (976-111) 15-07 65, 0915 280

№ 2079 25 К / № 62-14/178

Танай _____ Иргэн / Иргэн / № _____

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ИРГЭН,
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД

**Хүүхдийн тоглоомын аюулгүй
байдлыг хангах тухай**

Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад нь худалдан борлуулж байгаа болон үйл ажиллагаандаа ашиглаж буй хүүхдийн тоглоомын чанар, ашиглалт, техникийн болон үйлчилгээний аюулгүй байдалдаа Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, Эрчим хүчний тухай хуулиуд, MNS ISO- 8124-1:2010 "тоглоомын аюулгүй байдал, физик болон механик шинж чанартай холбоотой аюулгүй байдлыг тодорхойлох" MNS ISO 8124-2:2011 "Тоглоомын аюулгүй байдал Зарим элементүүдийн шилжилт" стандартууд, холбогдох норм дүрмийн заалтуудыг бүрэн хангаж ажиллах нь болзошгүй босол, аюулаас урьдчилан сэргийлэх тэдгээрээс үүсч болох хор хохирлыг багасгахад чухал ач холбогдолтой юм.

Иймд иргэн, аж ахуй нэгж байгууллага /хур Монгол улсын хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн тоглоом бусад техник хэрэгслээр үйлчилж, хамтран ажиллах болон түрээсийн гэрээнд аюулгүй байдлыг ханган ажиллах холбогдох заалтуудыг оруулж техникийн болон үйлчилгээний аюулгүй байдлыг дотоод хяналт хийж, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг мэдэгдэж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28-р зүйлийн 28.1.4 дэх заалтын дагуу тоглоомын талбайд үүсч болохгүй эрсдэлүүдийг тооцон, үнэлгээ хийх.

2. Мөн хуулийн 28.1.6 дахь заалтын дагуу тэдгээрт тохирсон аюулгүй ажиллагааны заавар боловсруулж, зааварчилгаа өгч, иргэд, олон нийтэд зориулсан аюул, ослоос урьдчилан сэргийлэх санамжуудыг байгуулах.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2 дахь заалтуудын дагуу тоглоомын аюулгүй байдлыг хангах нь тоглоомын талбайд суурилуулсан тоглоомын машинуудын техник ашиглалтын шаардлагыг бүрэн хөтөлж, техникийн баримтат заасан хугацаанд засвар үйлчилгээ тохиромжтойгоор тогтмол хийж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх.

4. Цахилгааны шугам, сүлжээ туслах төхөөрөмжүүдийн ашиглалтын явцад тусгаарлах шинж чанараа алдсан гэмтэлтэй кабель утас, разетка, холболтыг хайрцаг, залгуур цахилгаан хэрэгслийг /Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 1.1.8 дэх заалтын /цахилгаан байгууламж, тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангахаар бүрэн бүтэн байх ёстой/-г хэрэгжүүлэн ашиглахгүй байх.

5. Цахилгаан тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдлыг хангах нь тусгаарлах буулт болон газардуулгын эсэргүүцлийг /хур борооны улирал эхлэх өмнө 1000 В хүртэл хүчдэлтэй агаарын шугамын төмөр бетон тулгуурт тавигдсан хангируулагчийн хэрэгслийн дэгээ болон тулгуурын арматурын газардуулга бүрэн хангахаар бүрэн хөтөлж /цахилгаан аж ахуй

213010490746

хариуцагчийн үзэмжээр/ шалгана. Нойлын даг-жуулагч утастай бол дээрх элементийн нойлтуулгын байдлыг шалгана./ гэсэн "Хэрэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм"-ийн 2.8.10 дахь заалтын дагуу эрх бүхий байгууллагаар хэмжүүлж акт протоколоор баталгаажуулсан байх.

6. Тоглоом техник хэрэгслийг угсарч суурилуулах, тэдгээрийг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа MNS ISO 8124-1:2010 "Тоглоомын аюулгүй байдал. Физик болон механик шинж чанартай холбоотой аюулгүй байдлыг тодорхойлох" MNS ISO 8124-2:2011 "Тоглоомын аюулгүй байдал. Шатамхайн шинж чанар MNS ISO 8124-3:2011 "Тоглоомын аюулгүй байдал. Зарим элементүүдийн шилжилт" стандартуудын дараах шаардлагыг ханган ажиллах. Үүнд:

-Хөдөлгөөнт тоглоомыг ямар нэгэн байгууламжаас дор хаяж 1,8м зайд байрлуулах эсвэл хашаа, граж байшин гэд. унжсан салхи мөчир, угаалгын газрын шугам хоолой, цахилгааны утас зэрэгт саад учруулахгүй гэнэ суурилуулах.

-Энгийн хэрэглээний үед боловсролын аюулгүй тохиолдлоор буруу хэрэглэх явцад тулгуурын бусад элементүүд өргөгдөх, бэхлэгээний хэрэгсэл мултарч хөмрөхөөс сэргийлэхийн тулд зангуу, гадас зэрэг бэхлэгээг хөрсний бүтцийг онцгой анхаарч суурилуулах.

-Бүдрэх тээглэх аюулыг багасгахын тулд зангуу, гадсыг газартай тэгшлэх эсвэл газарт булах.

-Дүүжин даажин, савлуур, гулс, цэвэр хурээ зэрэг хөдөлгөөнт тоглоомуудын зааварт элс хөөс хаймар модны хамтрал, гадас зэргийн нөлөө суурилуулахад хэрхэн нөлөөлөхийг анхаарах.

-Эрэг боолтыг чангалсан эсэхийг байнга шалгаж, шаардлагатай бол дахин чангалах.

-Бүх метал хөдөлгөөнт хэсгүүдийг цэвэр байх.

-Хурц ирмэгтэй боолт, эргийн гэнэний байдал, шаардлагатай бол солих.

-Савлуурын сандал гинж, олоо, хавсраг эд ангиудын муудсан эсэхийг шалгаж шаардлагатай бол үйлдвэрлэгчийн зааврын дагуу сольж байх.

7. Аж ахуй нэгж байгууллага иргэн нь олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж буй үйлчилгээний талбайнаа гэрхирлын болон чанарын гэрчилгээгүй, зориулалтын бус/ азот, гелийгээс бусад хурц газар цэнэглэсэн агаарын бөмбөлгийг худалдаалахыг хориглох.

8. Засгийн газрын 2011 онд баталсан тогтоолоор баталсан Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу хамтран ажиллах болон түрээсийн гэрээнд аюулгүй байдлыг ханган ажиллах холбогдох заалтууд гэрүүлж техникийн болон үйлчилгээний аюулгүй байдалд дотоод хяналтыг тусгайлан зохион байгуулах.

Шалгалтаар хууль тогтоомжийн шаардлагыг гэрүүлж ажиллаагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагад "Зөрчлийн тухай" хуулийн 10.15, 11.2 дугаар зүйлийн холбогдох заалтын дагуу захиргааны хариуцлагыг дагуу гэрүүлж болно.

ДАРГА

Д.ЦЭНД-ОЧИР



НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
ПРОКУРОРЫН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Үйл ажиллагаа, ашиглалтыг түр
зогсоох тухай

Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Б.Гипэлмаа би Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбатаас 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн З.Ганбатад холбогдох зөрчлийн хэрэгт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа явуулж байгаа 6 дугаар цэг нь хүнсний стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоох тухай санал, холбогдох зөрчлийн 1802000291 дугаартай хэргийг 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч хянаад ОЛСОН нь:

Иргэн З.Ганбат нь Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсийн гэрээгээр түргэн үйлчилгээний цэг ажиллуулахдаа хүнсний стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх журам зөрчиж, хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/-ийн үйл ажиллагаа явуулсан нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэг, Худалдааны газрын ангилал, нэр томъёо MNS 6506:2015 стандартын 4.5.7, Хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005 стандартын 3.6, 5.1.1, 5.5.2, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хийсэн түрээсийн гэрээний 4.1 дэх заалтуудыг зөрчсөн, хүний эрүүл мэндэд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн байх тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Зөрчлийн 1802000291 дугаартай хэрэгт иргэн З.Ганбатын Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хоол үйлдвэрлэл /хуушуур хийх/ явуулж буй үйл ажиллагааг түр зогсоосугай.
2. Зөрчлийн хэргийн холбогдогч З.Ганбат Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг тайлбарлан өгсүгэй.
3. Прокурорын тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг даруй хэрэгжүүлэхийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Идэрбатад даалгасугай.

ХЯНАЛТЫН ПРОКУРОР, ХУУЛЬ
ЦААЗЫН АХЛАХ ЗӨВЛӨХ



Б.ГИПЭЛМАА

ТАНИЛЦСАН:
ХОЛБОГДОГЧ

З.ГАНБАТ

0610503



НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР



ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ



ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО



1. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн №140 тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгавар

2. НМХГ-ын улсын /ахлах/ байцаагчдын 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 02-06-271/631, 02-06-058/633, 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 02-02-224/671 тоот хамтарсан 22 заалт бүхий албан шаардлагын биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэгдсэн.

ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА



1. Хүнсний чанар, стандартын хяналт
2. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт
3. Дэд бүтцийн хяналт
4. Хөдөлмөрийн хяналт
5. Байгаль орчны хяналт

2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 12-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.




НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР



Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хийгдсэн хяналт шалгалт

2018.08.01

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн талаархи товч мэдээлэл



"Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь Нийслэлийн Туул голын ундны эх үүсвэрийг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулан ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, олон нийтийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл эко орчныг бүрдүүлэх зорилгоор 2009 онд байгуулагдсан.

Байгууллага тус газарт 4 зорилт дэвшүүлэн ажилладаг. Үүнд:

1. Эко ногоон бүс бий болгох;
2. Нийслэлийн иргэдийн чөлөөт цагаа эрүүл, аюулгүй, тохилог орчинд зөв боловсон өнгөрөөх, цогц орчин бий болгох;
3. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж нэмэгдсэнээр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах;
4. Ундны усны эх үүсвэрийг хамгаалах;

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ нь 9014001038 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд Цэцэрлэгт хүрээлэн зориулалтаар 2014 оны 04 сарын 04-ний өдрийн "Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн талбайн хэмжээ, зориулалт өөрчлөх, байршил шилжүүлэх тухай" А/234 тоот шийдвэрээр 9732945 м² газрыг эзэмшүүлсэн байна.

Тус газар нь ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг. Гүний 3 худгаас цэвэр усаар хангагддаг, зөөврийн ариун цэврийн 3 байгууламжтай /жорлон/, тэдгээрт 5 тн хэмжээтэй сав суулгасан ба УСУГ-аас гэрээний дагуу бохирыг соруулж зөөвөрлөдөг байна. Хоол үйлдвэрлэлийн цэгүүд нь зөөврийн устай, бохирын нэгдсэн системгүй байна.



ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
ОНӨТҮГ-ЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУУЛ
ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

Энхтайваны гудамж 17, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 210349
Утас/Факс: (976-11) 45-07-55, 7015-1286

2019.07.01 № Ох-14/216

танай _____ -ны № _____ -т

Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшлийн зам талбайд шорлог худалдаалж байгаа иргэд их хэмжээгээр утаа гарган оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг алдагдуулж байгаа талаар Парк сайд, Нарлаг өргөө хотхон, Их монгол хорооллын оршин суугчдаас удаа дараалан ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар зөвшөөрөлгүй цэгт шорлог хийж их хэмжээний утаа гарган, хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа 5 иргэнд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ногдуулж, хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.

Иймд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалтын дагуу дотоодын хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, шорлог хийж байгаа үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдье.

ДАРГА

Д.ЦЭНД-ОЧИР

213010400767